



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 32 (413)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Ой тэмдэглэх талаар чиглэл өгөх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *"40000 орон сууц" хөтөлбөр батлах тухай*
- *Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай*
- *Гамшгаас хамгаалах улсын албад байгуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны наймдугаар сарын 30

№32 (413)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

913.	Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, орон тооны тухай	Дугаар 35	686
914.	Ой тэмдэглэх талаар чиглэл өгөх тухай	Дугаар 36	687

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

915.	"40000 орон сууц" хөтөлбөр батлах тухай	Дугаар 144	688
916.	Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай	Дугаар 148	699
917.	Жагсаалтад нэмэлт оруулах тухай	Дугаар 150	699
918.	Ажилд томилох тухай	Дугаар 151	700
919.	Ерөнхий байцаагчийн эрх олгох тухай	Дугаар 152	700
920.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 153	700
921.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 154	701
922.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 155	701
923.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 156	701
924.	Гамшгаас хамгаалах улсын албад байгуулах тухай	Дугаар 158	702
925.	Журам батлах тухай	Дугаар 159	702
926.	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв байгуулах тухай	Дугаар 160	704



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 8 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, орон тооны тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын бүтэцтэй уялдуулан Тамгын газрын дүрэм, дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, энэ оны 10 дугаар сарын 1-ний дотор багтаан баталж мөрдөхийг Тамгын газрын дарга (Т.Билэгт)-д даалгасугай.

3. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 45 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2005 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн
35 дугаар зарлигийн хавсралт № 1*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Зэрэглэл	Орон тоо
1.	Тамгын газрын дарга	ТӨ-YA	1
2.	Ерөнхийлөгчийн зөвлөхүүд <i>(Улс төрийн бодлогын, Нийгмийн бодлогын, Эдийн засгийн бодлогын, Хуулийн бодлогын, Гадаад бодлогын, Цэргийн бодлогын, Орон нутгийн хөгжлийн бодлогын, Төрийн бус байгууллага хариуцсан)</i>	ТӨ-YIA	8
3.	Тамгын газрын дэд дарга	AA-1	1
4.	Албаны дарга <i>(Зөвлөхүүдийн ажлын албаны, Зохион байгуулалтын албаны, Бичиг баримт боловсруулах албаны, Хэвлэл мэдээллийн албаны)</i>	AA-3	4
5.	Ахлах референт	AA-5	7
6.	Референт	AA-6	23
7.	Шинжээч	AA-8	2
8.	Ахлах зааварлагч	AA-9	1
9.	Олшруулагч	TY-4	1
10.	Бичээч	TY-4	2
БҮГД			50

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Ой тэмдэглэх талаар чиглэл өгөх тухай

Их Монгол улсыг анхлан үндэслэгч бод Чингис хааны зарлигаар монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг байгуулах үндсийг тавьсны 785 жилийн ой энэ онд тохиож байна. Монголын эзэнт улсын Их хааны зарлигийн ёсоор Хархорум хотыг үүсгэн байгуулж эхлээд Өгөөдэй хааны үед 1235 онд цогцлоон бүтээж нээсэн нь монголын төдийгүй дэлхийн соёл иргэншлийн түүхэнд тэмдэглэгдэн мөнхөрсөн сод үйл явдлын нэг мөн.

Нийслэл Хархорум хот олон зууны түүхийн нугачаанд элж бүдгэрсэн хэдий ч тухайн цаг үедээ манай гаригийн олон орныг хамарсан монголын эзэнт улсын улс төр, соёл боловсрол, шашин мөргөл, худалдаа, эдийн засаг, үйлдвэрлэлийн төв төдийгүй дэлхийн улс түмний найрсаг харилцааны зангилаа болж түүхэнд онцгой чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

Монгол улс орчин үеийн ардчиллын замд зоримог шилжсэн XX-XXI зууны зааг дээр манай ард түмний улс төр-нийгмийн ухамсар сэргэн шинэчлэгдэж, эх оронч үндэсний үзэл оюун санааных нь амьдралын язгуур үндэс болсны үрээр өөрийн орны өв уламжлал болсон эзэнт гүрний эртний нийслэлээ жишиг хотын хэмжээнд сэргээн байгуулах санаачилга гарган, энэ талаар авч байгаа анхны арга хэмжээнүүдийг өргөнөөр дэмжсээр байна. Энэ санаачилга, хөдөлгөөнийг нэгтгэн судалж санал төсөл боловсруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын дарга 2004 онд захирамж гарган Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулсан билээ. Уг ажлын хэсэг "Эртний нийслэл Хархорумыг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр"-ийн төсөл боловсруулсныг Засгийн газар хэлэлцээд саяхан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Энэ хөтөлбөрийг батлагдахын өмнө шийдвэрлэж, зохих бэлтгэл хангах шаардлагатай зарим асуудал тулгамдаж байгааг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн гурав дахь заалт болон түүхэн үйл явдлыг тэмдэглэх талаархи нийтлэг журмыг баримтлан ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

Нэг. Хархорум хот үндэслэн байгуулагдсаны 785 жилийн ойг 2005 оны 9 дүгээр сард ёслон тэмдэглэсүгэй.

Хоёр. Энэхүү түүхэн ойг тэмдэглэх ажлыг бэлтгэж, зохион байгуулах талаар дор дурдсан арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосугай:

2.1. 2006 онд тохиох их Монгол Улс байгуулагдаж, Тэмүүжинг Их хаанд өргөмжилсний 800 жилийн ой угтсан ажлын хүрээнд Хархорумыг сэргээн байгуулах асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажлын хэсэг болгож, тус хотыг үндэслэн байгуулсны ойг угтан тэмдэглэх төлөвлөгөө, төсвийг боловсруулж, зохих журмын дагуу батлан, мөрдөх;

2.2. Хархорум хотыг байгуулах дэвсгэр газрын зааг (хил), цар хэмжээ, хөрс, ус, экологийн аюулгүй бүх талын зохистой, нөхцөл ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээний, ялангуяа хүн амын ундааны усны эх нөөц түүнийг зохимж, маркшейдерийн болон шинэ хуучин хотын түүхэн хэлхээ, түүх соёлын дурсгалт газар, зүйлсийг хөндөхгүй байхуйцаар хамгаалахтай холбогдоон мэргэшлийн магадлан шинжилгээг ШУА, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагаар хийлгэж, дүгнэлт гаргуулах зэргээр хотын дэвсгэр газрын сонголтыг эцэслэн тогтож УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх.

2.3. Хотын дэвсгэр газрын сонголтыг үндэслэн оршин суугчдын засаг захиргааны харьяалал, нийтийн үйлчилгээний бүтцийн бүдүүвчийг боловсруулж тогтоосон журмын дагуу шийдвэрлүүлэх.

2.4. Хархорум хотын 785 жилийн ойг угтан жишиг хотын төв цэгийг тодорхойлж төрийн ёслолын хэмжээнд хүндэтгэлийн суурь шав тавих бэлтгэл хангах;

2.5. Хархорум хотын үндэслэн байгуулагдсаны түүхт ойн арга хэмжээг нийтэд сурталчлаж, иргэний нийгэм, төрийн бүс байгууллагуудын санаачилгыг дэмжсэн хөдөлгөөн өрнүүлж, уг ажилд тухайн бүс нутгийн засаг захиргааны байгууллагуудыг татан оролцуулах.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н. ЭНХБАЯР
**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц. ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

"40000 орон сууц" хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "40000 орон сууц" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт ёсоор, "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах, гадаад, дотоодын байгууллага, компанийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаяр, Сангийн сайд Н.Алтанхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер болон бизнес төлөвлөгөөг боловсруулан баталж, бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаярт даалгасугай.

4. "40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд аймаг, нийслэлд баригдах орон сууцны газрын байршлыг тогтоон зохих журмын дагуу шийдвэрлэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтад дараахь агуулга бүхий 40 дүгээр заалт нэмсүгэй:

40.	"40000 орон сууц" хөтөлбөрийн үндэсний хороо	Барилга, хот байгуулалтын сайд
-----	--	--------------------------------

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД Н.БАТБАЯР

Засгийн газрын 2005 оны 144 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"40 000 ОРОН СУУЦ" ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Удиртгал

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, тэдгээрийг тогтвортой ажлын байр, тохилог орон сууцаар хангах талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд "40 000 орон сууц" хөтөлбөрийн үндсэн зорилго оршино.

Хөтөлбөр хэрэгжсэнээр ажлын байр, орон сууцны нийлүүлэлт, иргэдийн худалдан авах чадварыг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулахаас гадна нийгмийн сэтгэл зүйд зэрэг уур амьсгал бий болгож, иргэдийн ажиллаж хөдөлмөрлөх эрмэлзлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

1.2 Үндэслэл, шаардлага

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх "40 000 орон

сууц" хөтөлбөр нь өнөөгийн нийгмийн өмнө тулгарч байгаа ажилгүйдэл, түүнээс улбаатай ядууралтай тэмцэх цогц үйл ажиллагаа болох бөгөөд барилгын салбарыг хөгжүүлэх замаар ажлын байр шинээр бий болгож, иргэдийн амьжиргааны түвшин, ахуй орчныг сайжруулах бодит хүчин зүйл болох юм.

Өнөөгийн байдлаар Монголын хүн амын 20 хувь нь цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээнд холбогдсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн орчинд амьдарч байна.

Сүүлийн жилүүдэд барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж байгаа, татвар хоцрогдсон норм, дүрэм болон төсвийн үнэлгээ, шинэ техник, технологи болон мэргэшсэн боловсон хүчний хомсдол, оновчтой бус санхүүгийн тогтолцоо зэрэг сөрөг хүчин зүйлс барилгын салбарын хөгжлийг удаашруулж байна. Манай улсад хүн амын орон сууцны хэрэгцээ их байгаа боловч сүүлийн жилүүдэд ердөө 7,6 мянга гаруй орон сууц ашиглалтад орсон нь хангалтгүй тоо юм. 2004 оны

байдлаар орон сууцны 1 ам дөрвөлжин метр талбайн үнэ дунджаар 350-400 мянган төгрөгт хүрээд байна. Нийтийн орон сууцны 1-3 өрөө байрны үнэ байршил, барилгын хийц, загвараас шалтгаалан 12-30 сая төгрөг байгаа нь иргэдийн дийлэнх хувийн худалдан авах чадвараас өндөр байгаа бөгөөд бага орлоготой болон ядуу иргэдийн хувьд орон сууцтай болох боломж туйлын хомс байгаа билээ. Иргэдийн худалдан авах чадвар сул, орон сууцны үнэ харьцангуй өндөр байгаа нь барилгын салбар, тэр дундаа орон сууцны бодлогод төрийн идэвхитэй зохицуулалт үгүйлэгдэж байгааг харуулж байна.

Үүний зэрэгцээ хот руу хандсан хүн амын шилжих хөдөлгөөн ихэссэн нь хот төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа бөгөөд үүнийг шийдвэрлэхэд орон сууцны цогц хөтөлбөр чухал үүрэг гүйцэтгэх юм.

Дэд бүтэцгүй, төлөвлөлт муутай гэр хороолол агаар, хөрс, усны бохирдлыг ихэсгэж байна. Улаанбаатар хотын гэр хорооллын 90-ээд мянган өрх жилдээ 300 гаруй мянган тонн нүүрс, 250 орчим мянган шоо метр мод түлж, их хэмжээний хорт утаа, угаарын хийгээр хотын агаар, орчныг бохирдуулж байгаа билээ.

Гэр хорооллын нэг хүний өдрийн усны хэрэглээ 5-7 литр байгааг Улаанбаатар хотын инженерийн хангамжтай орон сууцны нэг хүний хэрэглээ 250 литр байгаатай харьцуулахад хэтэрхий доогуур үзүүлэлт юм. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 2-т тунхаглагдсан "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах" иргэний үндсэн эрхийг хангах зорилгоор иргэдийн амьдрах орчин, орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Манай улсын нийт хүн амын 54 хувийг 25 хүртэлх насны залуучууд эзэлдэг бөгөөд 2003 оны байдлаар 15-19 хүртэлх насны 263,3 мянган залуучууд байна. Эдгээр залуучууд нь 2005-2010 онд хөдөлмөрийн насанд хүрч, манай улсын орон сууцны цаашдын хэрэгцээг эрс нэмэгдүүлэхээр байна. Энэхүү эрэлтийг угтсан бодлого боловсруулах нь Засгийн газрын хэтийн зорилготой уялдаад зогсохгүй орон сууцны хангамжийн асуудлыг шийдвэрлэх нь гэр бүл болон нийгмийн тогтвортой байдалд зэрэгээр нөлөөлөх болно.

Иймд богино хугацаанд цогцолбор арга хэмжээ авч, тохилог орон сууцанд амьдрах иргэдийн тоог нэмэгдүүлэх, орон сууцны нэг талбайн өртгийг бууруулах, ажлын байр бий болгох замаар иргэдийг ядуурлаас гаргаж, тэднийг

амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгох шаардлага тавигдаж байна. "40 000 орон сууц" хөтөлбөр нь эдгээр асуудлуудыг шийдвэрлэх цогц бодлогыг тодорхойлох бөгөөд Монголын барилгын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх юм.

1.3. Орон сууцны салбарын өнөөгийн байдал

Монгол Улсын хүн амын 49,1 хувь нь 6878 мянган ам дөрвөлжин метр сууцны талбай бүхий 265,5 мянга гаруй байшин сууцанд, 50,9 хувь нь 275,6 мянга орчим гэр сууцанд тус тус амьдарч байна. Үүнээс зөвхөн 20 орчим хувь нь тохилог орон сууц буюу халаалт, халуун, хүйтэн ус, бохир усны шугам сүлжээнд холбогдсон, эрүүл ахуйн шаардлага хангасан байранд амьдарч байна.

Нэг хүнд ногдох сууцны талбай хотод 6,7 ам дөрвөлжин метр, хөдөөд 5,6 ам дөрвөлжин метр байгаа нь манай улсын нормын жишиг хэмжээнээс 30-40 хувь, олон улсын нормын жишиг хэмжээнээс 2 дахин бага байна.

Гэр болон орон сууцны хорооллын ахуйн нөхцөлийн ялгаа хэт их, орон сууцны үнэ өндөр, иргэдийн худалдан авах чадвар сул, орон сууцны урт хугацааны зээлийн тогтвортой тогтолцоо бий болоогүй, улсын төсвийн хөрөнгө хүрэлцээгүй зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж хүн амыг орон сууцаар хангах цогц бодлого үгүйлэгдэж байна.

1.4. Олон улсын туршлага

Дэлхийн ихэнхи улс орон хүн амаа орон сууцаар хангах тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, 1990-ээд онд ХБНГУ 550 мянган орон сууц, БНСУ 2 сая орон сууц, Малайз Улс 800 мянга, Этиоп Улс жил бүр 40 000 орон сууц барих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлжээ. Эдгээр улс нь орон сууцны дэд бүтцийг барьж байгуулах ажлыг бүрэн хэмжээгээр улсаас санхүүжүүлдэг байна.

Ихэнх улс орнууд орон сууц хөгжүүлэх сан болон бусад хөрөнгийн эх үүсвэрээр бага орлоготой иргэдийг түрээсийн байраар хангаж, дунд орлоготой иргэдэд орон сууцны урт хугацаатай зээл олгох замаар иргэдээ орон сууцаар хангадаг байна. Тухайлбал, орон сууцны урт хугацаатай зээлийн үлдэгдэл тухайн орны дотоодын нийт бүтээгдэхүүнд өндөр хувь эзэлж байна. Жишээ нь Данид 70, Нидерландад 66, Англид 59, Германд 50, Америкт 53, Сингапурт 59, Японд 35 хувьтай тэнцэж байхад энэ үзүүлэлт хөгжиж буй орнуудад дөнгөж 3-10 хувьтай байна.

Улс орнуудын орон сууцны бодлогын хувьд орон сууцны салбарын эрх зүй, татварын зохистой зохицуулалт, орон сууцны зориулалттай урт хугацааны зээлийн тогтолцоо, улсын төсвийн зарцуулалт, төрийн хяналт зэрэг хүчин зүйлс чухал ач холбогдолтой байдаг байна. Олон улсын туршлага болон өнөөгийн нийгмийн өмнө тулгарч байгаа онцгой шаардлагуудыг харгалзан үзсэн орон сууцны цогц бодлого боловсруулж, Монголын хүн амын амьжиргааны түвшин, улс орны хэтийн хөгжилд хувь нэмэр оруулах нь "40 000 орон сууц" хөтөлбөрийн зорилго юм.

1.5. Хөтөлбөрийн нэр томъёо

Хөтөлбөрт дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

"Орон сууц" гэж Орон сууцны тухай хуулийн

3.1.1-д тодорхойлсноор;

"Нийтийн орон сууц" гэж Орон сууц хувьчлах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д тодорхойлсноор;

"Амины орон сууц" гэж эдлэн газартай болон эдлэн газаргүй орон сууцыг;

"Орон сууцны дэд бүтэц" гэж Орон сууцны тухай хуулийн 3.1.2-т тодорхойлсноор;

"Орон сууцны анхан шатны дэд бүтэц" гэж төвлөрсөн цахилгаан хангамж, цэвэр, бохир усны хэсэгчилсэн системийг;

"Орон сууцны анхан шатны дэд бүтэц бүхий орон сууц" гэж цахилгаан, цэвэр, бохир усны хэсэгчилсэн системд холбогдсон эдлэн болон эзэмшил газартай орон сууц болон гэрийг;

"Хүн төвтэй, тогтвортой хот байгуулалтын бодлого" гэж хүний сайн сайхны төлөө чиглэсэн зорилготой, байгаль орчин, нөөц баялгаа хамгаалсан, эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилтэй нийцсэн хот байгуулалтын бодлогыг.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

2.1. Хөтөлбөрийн зорилт

Үндэсний онцлог байдлыг харгалзахын зэрэгцээ олон улсын туршлагыг тусгасан хот байгуулалтын оновчтой бодлого хэрэгжүүлэх, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, орон сууцны урт хугацаатай зээлийн тогтолцоог бүрдүүлэх, барилгын салбарт эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, гэр хороолол болон хотын захын ашиглалтгүй байгаа талбайд орон сууцны

дэд бүтцийг барьж байгуулах замаар иргэдийн худалдан авах чадвар, шаардлагад нийцсэн өртөгтэй, чанартай 40 000 орон сууц барих нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн орон сууцны эрэлт, нийлүүлэлт, удирдлага зохион байгуулалтын цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн үндсэн зорилт оршино.

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлүүд

"40 000 орон сууц" хөтөлбөрийг 5 жилийн хугацаанд дараахь гурван үндсэн чиглэлийн хүрээнд 90 орчим хувийг нийслэлд, 10 орчим хувийг бүсийн тулгуур төв хот болон аймгуудад хэрэгжүүлэх бөгөөд нэг аймагт 200-гаас доошгүй орон сууц барина:

2.2.1. Нэгдүгээр чиглэлийн хүрээнд:

Нийтийн зориулалттай 10 000 орон сууц барина.

а/хотын доторхи ашиглагдаагүй газарт одоо байгаа дэд бүтцийг сайжруулах замаар шинээр орон сууцны байр барих;

б/оршин суугчдын санаачилгын үндсэн дээр хуучин барилгуудыг буулгаж шинээр дахин барих;

в/техникийн шаардлага хангасан барилгад технологийн дагуу давхар нэмэх;

г/инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдоогүй орон сууцыг шугам сүлжээнд холбох байдлаар нөхцөлийг нь сайжруулах;

д/орон сууцны дуусаагүй барилгыг гүйцээн бэрж ашиглалтад оруулах;

е/ашиглалтгүй байгаа барилгыг орон сууцны зориулалтаар засварлан ашиглалтад оруулах.

2.2.2. Хоёрдугаар чиглэлийн хүрээнд:

а/хотын захын ашиглагдаагүй байгаа газарт шинээр орон сууцны дэд бүтэц барьж 15 000 орон сууц бүхий шинэ хотхон, хороолол барина;

б/хотын захын ашиглагдаагүй талбайд орон сууцны инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц бий болгох;

в/орон сууцны хорооллыг соёл, нийгэм ахуйн барилга байгууламжийн хамтаар барих.

2.2.3. Гуравдугаар чиглэлийн хүрээнд:

а/гэр хорооллыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож 15 000 айлын орон сууцны нөхцөлийг сайжруулах замаар эдгээр гэр хорооллыг орчин үеийн тусдаа орон сууцны хотхон болгон хөгжүүлэх бодлого баримтална;

б/гэр хорооллын төлөвлөлтийг иргэдийн оролцоо, санаачилгын дагуу боловсронгуй болгон сайжруулах;

в/гэр хорооллыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох замаар гэр хорооллыг амины тохилго орон сууцны хороолол болгон хөгжүүлэх;

г/зарим боломжтой газрыг дулааны шугам сүлжээтэй болгох.

2.3. Барилга, хот байгуулалтын салбарын хөгжил

Дээрх үндсэн гурван чиглэлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд барилга, хот байгуулалтын салбарын хөгжлийг шинэ түвшинд гаргана:

2.3.1. хот байгуулалт, барилгын норм, дүрмийг шинэчилж, өртөг багатай орон сууцны шинэ стандартыг бий болгох;

2.3.2. барилга байгууламж, орон сууцны мэдээллийн нэгдсэн системийг бий болгох;

2.3.3. барилга байгууламжийн өртгийг тодорхойлох ажлыг хялбар болгон барилгачдын цалинг нэмэгдүүлэх зорилгоор төсвийн томсгосон үнэлгээг бий болгох;

2.3.4. барилгын салбарт шинэ техник, технологи нэвтрүүлж, машин механизм, тоног төхөөрөмжийг лизингээр худалдан авах, түрээсээр ашиглах боломжийг бий болгох;

2.3.5. барилгын салбарын мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, мэргэжилтэй ажилчдыг давтан сургах, шинэ техник, технологийг эзэмшүүлэх, багш нарын заах арга зүйг сайжруулах;

2.3.6. барилгын эрдэм шинжилгээ, зураг төсөл, барилга угсралтын байгууллага, барилгын материалын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж шууд болон шууд бус замаар шинэ ажлын байр бий болгох;

2.3.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын норм, дүрмийг бий болгон барилгын төлөвлөлтийн зураг төсөлд тусгуулж хэрэгжүүлэх;

2.3.8. барилгын чанарын хяналтыг сайжруулж, барилгын материалын чанарын төлөө хүлээх хариуцлагын тогтолцоог бий болгож барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх асуудлыг тусгай зөвшөөрөлтэй болгох.

Гурав. Хөтөлбөрийн хууль, эрх зүй, эдийн засгийн орчин

3.1. Эрх зүйн орчин

Дараахь чиглэлээр асуудал боловсруулна:

3.1.1. орон сууц, түүний дэд бүтцийг барьж байгуулах ажил, анхан шатны дэд бүтцийн шугам сүлжээгээр гэр хорооллын иргэдийг цэвэр усаар хангах үйлчилгээ, орон сууц болон түүний хэсгийг борлуулах, орон сууц болон түүний дэд бүтцийн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулахад ногдог нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар;

3.1.2. өндөр үнэтэй болон орц ихтэй зарим нэр төрлийн барилгын материалын үйлдвэрийн импортын тоног төхөөрөмж, түүхий эд, машин механизмыг гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх талаар;

3.1.3. шинээр баригдсан орон сууцыг борлуулсны орлогын дүнд ногдох орлогын албан татвараас чөлөөлөх талаар;

3.1.4. улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хороолонд анхан шатны дэд бүтэц болон шинээр барих орон сууцны хорооллын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээг барьж байгуулах талаар;

3.1.5. хот байгуулалтын тухай болон газрын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар;

3.1.6. орон сууцны ипотекаар баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тогтолцооны талаар;

3.1.7. гадаадын хөрөнгө оруулалтад Засгийн газрын баталгаа гаргах болон бонд гаргах, гадаадын хөрөнгө оруулалтаар баригдсан орон сууц, түүний дэд бүтцийг худалдан авах талаар.

3.2. Гадаадын хөрөнгө оруулалт

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ:

3.2.1. орон сууц, түүний дэд бүтэц барих газрыг олгох чиглэлээр;

3.2.2. тогтвортой байдлын гэрээ байгуулах чиглэлээр;

3.2.3. шаардлагатай тохиолдолд харилцан тохиролцсон үнийн үндсэн дээр орон сууц, түүний дэд бүтцийг Засгийн газар худалдан авах чиглэлээр;

3.2.4. ногдол ашгийн албан татвараас чөлөөлөх чиглэлээр.

3.3. Эдийн засгийн болон нийгмийн орчин

Хүн амыг орчин үеийн тохилог орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлнэ;

3.3.1. орон сууцны анхан шатны дэд бүтэц болон шинээр барих орон сууцны хорооллын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг төр хариуцаж, жил бүр хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж иргэдийг орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлнэ;

3.3.2. орон сууцны урт хугацаатай эзэлийн тогтолцоо бий болгоно;

3.3.3. шинээр баригдах орон сууцанд сэргээгдэх эрчим хүч, шингэрүүлсэн шатдаг хийн түлшний технологийг нэвтрүүлэхийн зэрэгцээ ахуйн хэрэглээнд өргөн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлнэ;

3.3.4. төрийн албан хаагч, нийгмийн эмзэг хэсгийн иргэд хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болох нөхцөлийг бий болгох зорилгоор орон сууцны дэд хөтөлбөрүүдийг тусгайлан боловсруулж хэрэгжүүлнэ;

3.3.5. бага, дунд орлоготой өрх, залуу гэр бүлд зориулсан түрээсийн орон сууцны хэлбэрийг бий болгоно;

3.3.6. сумын төвд ажиллаж байгаа багш, эмч нарын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээ авна.

Дөрөв. Санхүүжилт

4.1. Шаардагдах хөрөнгө, түүний зарцуулалт

Хөтөлбөрийн санхүүжилтэд ойролцоогоор 600 сая америк доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө шаардагдах урьдчилсан тооцоо гарч байна.

Дээрх хөрөнгийг:

-орон сууцны дэд бүтэц барьж байгуулахад 70,0 сая ам. доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө;

-нийтийн зориулалттай 10 000 орон сууц барихад 200,0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө;

-шинэ хотхон, хорооллод 15 000 орон сууц барихад 300,0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө;

-гэр хорооллыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбоход 30,0 сая ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө зарцуулахаар төлөвлөж байна.

4.2. Хамтын ажиллагаа, бодит боломж

Тус хөтөлбөрийн хүрээнд Монгол банк, Сангийн яам, салбарын яамд, олон улсын болон хоёр талт хамтын ажиллагааны байгууллагууд, арилжааны банкууд болон оролцогч бусад талуудтай нягт хамтран ажиллана.

Монгол банк нь арилжааны банкуудын гадаадад бага хүүтэйгээр байршуулсан мөнгийг дотоодын санхүүгийн зах зээлд оруулж ирэх нөхцөлийг бүрдүүлж, орон сууцны санхүүжилтийн хөрөнгийн эх үүсвэрийг зохицуулах эрх бүхий нэгжийг байгуулахад оролцоно. Түүнчлэн арилжааны банкуудад төвлөрсөн дотоодын хадгаламжийг бүрэн ашиглах хугацаатай хадгаламжид хамрагдах хөрөнгийг орон сууцны зориулалттай урт хугацааны эзэлийн зах зээл руу чиглүүлэх боломжийг ашиглах.

2004 оны байдлаар нийт хугацаатай хадгаламж 625,7 тэрбум төгрөгийн хэмжээтэй байсан бөгөөд 2003-2004 онуудад уг хадгаламж 27,6 хувиар өссөн байна¹. Энэхүү үзүүлэлт нь дотоодын эх үүсвэрийн чадавхи өндөр байгааг харуулаад зогсохгүй Засгийн газрын хувьд хөрөнгө оруулалт татах хангалттай орон зай байгааг харуулж байна.

4.3. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

4.3.1. улсын болон орон нутгийн төсвөөс орон сууцны дэд бүтэц барихад хуваарилсан хөрөнгө;

4.3.2. гадаадын банк, олон улсын санхүүгийн байгууллагын зээл, тусламж;

4.3.3. банк, санхүүгийн байгууллагын зээлийн хөрөнгө;

¹ Монгол банк, 2005 он

4.3.4. Засгийн газрын баталгаа гаргаж орон сууцны зориулалтаар оруулж ирсэн гадаадын хөрөнгө;

4.3.5. Засгийн газрын бонд болон ипотекеэр баталгаажсан үнэт цаасны борлуулалтын орлогын эх үүсвэр;

4.3.6. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө;

4.3.7. орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгө;

4.3.8. газрыг эдийн засгийн эргэлтэд оруулснаас бий болсон хөрөнгө;

4.3.9. бусад.

4.4. Хөрөнгийн төвлөрүүлэлт

4.5. Иргэдийн худалдан авах чадвар

Хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаа нь иргэдийн орон сууц худалдан авах чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн таатай орчин бүрдүүлэхэд чиглэнэ. Үүнд:

Хөтөлбөрийн хүрээнд орж ирэх дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусгай дансанд төвлөрүүлэн байршуулна.

4.5.1. Тогтмол орлогын эх үүсвэртэй иргэдийн хувьд:

Орон сууц худалдан авч байгаа иргэд төлбөрөө 100 хувь хийдэг өнөөгийн тогтолцоог өөрчилж, олон улсын жишиг болсон орон сууцны урт хугацаатай эзэлийн тогтолцоог нэвтрүүлэх буюу иргэд тодорхой хэмжээний урьдчилгаа төлөөд байрандаа орж, эзэлийн үлдэгдлийг 15-25 жилийн хугацаанд сарын тогтмол төлбөр хэлбэрээр төлж барагдуулдаг тогтолцоонд шилжинэ.

4.5.2. Бага, дунд орлоготой өрх, залуу гэр бүлийн хувьд:

Орон сууц худалдан авах санхүүгийн боломж муутай бага, дунд орлоготой өрх, залуу гэр бүлд зориулж тусгай дэд хөтөлбөр хэрэгжүүлэн эдгээр иргэдэд 1-2 өрөө бүхий орон сууцыг сарын тогтсон төлбөртэйгээр түрээслэнэ. Түрээсийн орон сууцыг гүйцэтгэгч байгууллагаас Засгийн газар худалдан авах бөгөөд үг хөрөнгө оруулалтыг урт хугацаатай бонд болон бусад санхүүгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

Тав. Удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах үүрэг бүхий Удирдах хороо ажиллана. Удирдах хорооны дарга нь барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна. Удирдах хорооны бүрэлдэхүүнийг дарга батална.

5.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулна.

5.4. Хөтөлбөрийн санхүүгийн механизмыг удирдан зохион байгуулах үйл ажиллагааг Монгол банк, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам хамтран зохион байгуулна.

Зургаа. Үр дүн, шалгуур үзүүлэлт, нөлөө

6.1. Хүрэх үр дүн

6.1.1. нийтийн зориулалттай 10 000 орон сууц ашиглалтад орсон байна;

6.1.2. хотын захын ашиглагдаагүй талбайд 15 000 орон сууц бүхий шинэ хотхон, хороолол ашиглалтад орсон байна;

6.1.3. гэр хорооллын 15 000 айлын орон сууцыг цэвэр, бохир усны шугамд холбох нөхцөлийг бүрдүүлсэн байна;

6.1.4. нэг хүнд ноогдох сууцны талбай 8 ам дөрвөлжин метрт хүрсэн байна;

6.1.5. орон сууцны үнийг иргэдийн худалдан авах чадварт нийцүүлсэн байна;

6.1.6. орон сууцны нийт талбайн хэмжээ 40-50 ам дөрвөлжин метрт хүрсэн байна;

6.1.7. бага, дунд орлоготой иргэдэд зориулагдсан түрээсийн орон сууцны тогтолцоо бүрдсэн байна;

6.1.8. орон сууцны урт хугацаатай эзэлийн тогтолцоо бүрдсэн байна;

6.1.9. машин механизмын лизинг, түрээсийн үйлчилгээ бий болж барилгын мэргэжилтэй ажилчдын ур чадвар өрсөлдөхүйц болсон байна;

6.1.10. агаар, хөрс, усны бохирдол багассан байна.

6.1.11. ажлын байр нэмэгдэж, тогтвор суурьшил болон бүтээмж өснө.

газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт хэрэгжинэ.

6.2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

6.3.4. ажлын байр шинээр бий болж, иргэдийн тодорхой хэсэг орлогын тогтмол эх үүсвэртэй болно.

6.2.1. ашиглалтад орсон орон сууцны тоо;

6.3.5. гадаадаас авах ажиллах хүчийг дотоодын ажилчдаар орлуулж, гадаадад гаргаж байгаа чадварлаг ажиллах хүчийг эх орондоо таатай нөхцөлд ажиллаж, амьдрах боломжоор хангана.

6.2.2. нэг хүнд ногдох сууцны талбайн хэмжээ;

6.2.3. түрээсийн орон сууцны тоо;

6.2.4. дэд бүтэц бүхий орон сууцтай хүн амын эзлэх хувь;

6.3.6. барилгын салбарт шинэ техник, технологи нэвтрүүлж, үндэсний үйлдвэрлэлийн баазыг нэмэгдүүлнэ.

6.2.5. орон сууцны үнэ, өрхийн орлогын харьцаа;

6.2.6. орон сууцны зээлийн нийт зээлд эзлэх хувь;

6.3.7. хот төлөвлөлтийн чанар дээшилж хотын үзэмж, газрын нягтрал, ашиглалт сайжирна. Үндэсний нийт бүтээгдэхүүнд барилгын салбарын эзлэх хувийн жин нэмэгдэж тус салбар улс орны эдийн засгийн хөдөлгөгч хүч болон хөгжинэ.

6.2.7. агаар, хөрс, усны бохирдлын хэмжээ буурсан үзүүлэлт;

Нийгмийн сэтгэл зүйн түвшин дэх хөтөлбөрийн нөлөө:

6.2.8. барилга, түүний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт шинээр бий болсон ажлын байрны тоо;

Хөтөлбөрийн үр дүнг дүгнэхдээ 2004 оны эхний хагас жилийн орон сууцны хангамжийн үзүүлэлтүүдийг суурь үзүүлэлт болгон ашиглана.

6.3.8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт амжилттай хэрэгжсэнээр Засгийн газрын үйл ажиллагаанд иргэдийн итгэх итгэл нэмэгдэнэ.

6.3. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх нөлөө

"40 000 орон сууц" хөтөлбөр нь орон сууцны хангамжийг нэмэгдүүлсэн, үндэсний үйлдвэрлэлийн хэмжээг өсгөсөн, ажилгүйдэл, ядуурал буурахад зохих нөлөө үзүүлсэн, бүхэлдээ нийгмийн идэвхи санаачилгыг өрнүүлсэн хөдөлгөгч хүч, баялгийг бүтээгч үйл ажиллагаа болох юм.

6.3.9. урт хугацааны зээлд хамрагдаж, тохилог орон сууцаар хангагдсан ажиллах хүчний тав тухтай орчинд тогтвор суурьшилтай хөдөлмөрлөх сонирхол нэмэгдэж, нийгэмд таатай уур амьсгал бүрэлдэнэ.

Ахуйн түвшин дэх хөтөлбөрийн нөлөө:

6.3.10. иргэдийн орон сууцны асуудлыг шийдсэнээр хүн ам зүйн бодлого хэрэгжих зэрэг орчин бий болно.

6.3.1. татвар, эрх зүй, санхүүгийн таатай орчин бүрдүүлснээр орон сууцны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж орон сууцны өөрийн өртөг буурна.

6.3.11. Эх орондоо тогтвортой ажиллаж, амьдрах итгэл нэмэгдэнэ.

6.3.2. ипотекаар баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийг хөгжүүлэн иргэдэд орон сууцны зориулалттай урт хугацааны зээл олгох санхүүгийн тогтолцоог бий болгож иргэдийн худалдан авах чадварыг нэмэгдүүлнэ.

"40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэд өөрсдийн анхдагч хэрэгцээний нэг болох орон сууцаар урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөл бүрдэж, улмаар амьжиргааны түвшингээ хадгалахын тулд шударгаар орлого олж, орлогын эх үүсвэрээ бүрдүүлэхийн тулд байнгын хөдөлмөр эрхэлж, идэвхи зүтгэлтэй, хичээнгүй хөдөлмөрлөж амьдралын хариуцлагатай байх хэв маягийг хэвшүүлэх эхлэл тавигдана.

6.3.3. орон сууцны бодлого цогц байдлаар хэрэгжин иргэдийн амьдрах орчин сайжирч Засгийн

"40 000 ОРОН СУУЦ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
1	40 000 орон сууцны байршил, хүчин чадлыг тодорхойлж орон сууц барих газрын асуудлыг шийдвэрлэх	2005	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
2	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах	2005-2007	БХБЯ, Нийслэлийн ЗДТГ
3	Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах	2005 -2007	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
4	Гэр хорооллыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах	2005-2006	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
5	Хот, тосгоны оршин суугчдын аюулгүй байдалд нийцэхгүй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцны хорооллыг шинэчлэн төлөвлөх	2005-2010	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
6	Хот байгуулалтын бодлоготой уялдуулан хот, тосгон, орон сууцны хорооллын төлөвлөлтийг олон нийтийн оролцоотой хийх чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2005-2010	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ

Б. Газар ашиглалтын үр ашгийг дээшлүүлж, хот суурины газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг шинэ түвшинд гаргах чиглэлээр

7	Орон сууц барих сул чөлөөтэй газрыг илрүүлэх, шинээр барих орон сууцны хорооллын газрын байршилг тогтоох ажлыг зохион байгуулах	2005	БХБЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
8	Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ерөнхий төлөвлөгөө, баригдах барилгуудын төлөвлөлтийг хийхэд шаардлагатай байр зүйн дэвсгэр зургаар хангах ажлыг зохион байгуулах	2005-2007	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
9	Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагад орон сууц барих газар олгох	2005-2007	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
10	Гэр хорооллыг дэд бүтэцтэй болгох, амины орон сууц барих ажлыг хэрэгжүүлэхдээ газрын эдийн засгийн харилцааг өргөжүүлэн газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчдийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авах	2005	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ газар

В. "40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль, эрх зүй, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх чиглэлээр

"40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараахь хуулиудын болон УИХ, Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх. Үүнд:			
а/ Хуулийн төсөл			

11	<p>-40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай;</p> <p>"40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаалийн албан татвараас чөлөөлөх тухай;</p> <p>"40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарим хуулийн заалтыг хамгааруулахгүй байх тухай;</p> <p>"40 000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарим хуулийн заалтыг хамгааруулахгүй байх тухай;</p> <p>Газрын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;</p> <p>-Хот байгуулалтын болон хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;</p> <p>-Берилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;</p> <p>-Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;</p> <p>"Употексэр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон уг хуультай холбогдож зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<p>2005 оны эхний хагас жилд</p> <p>2005 оны эхний хагас жилд</p> <p>2005 оны Ш, IV улиралд</p>	<p>БХБЯ</p> <p>БХБЯ</p> <p>БХБЯ</p>
12	<p>б/ Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл</p> <p>Гадаадын хөрөнгө оруулалтад орон сууцны зориулалттай Засгийн газрын бонд /баталгаа/ гаргах болон гадаадын хөрөнгө оруулалтаар баригдсан орон сууц, түүний дэд бүтцийг худалдан авах талаар</p>	<p>2005 оны Ш улиралд</p>	<p>СЯ, БХБЯ</p>
13	<p>в/ Засгийн газрын шийдвэрийн төсөл</p> <p>-Гадаадын хөрөнгө оруулагчдад Засгийн газрын бонд /баталгаа/ гаргах талаар</p> <p>-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх одор тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий "Орон сууц" корпораци" төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах талаар</p> <p>-Гадаадын хөрөнгө оруулалтаар баригдсан орон сууц худалдан авах талаар</p> <p>-Үнэт цаасны үйл ажиллагааг эрхлэх, хөтөлбөрийн санхүүгийн механизмыг удирдлан зохион байгуулах үүрэг бүхий хуулийн этгээдийг байгуулах талаар</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>2005 оны Ш улиралд</p> <p>2005 оны Ш, IV улиралд</p> <p>2005 оноос</p>	<p>СЯ, БХБЯ</p> <p>БХБЯ, СЯ, Монгол банк</p> <p>БХБЯ, холбогдох яамд, Нийслэл, аймгийн ЗДТГ</p> <p>БХБЯ, СЯ</p> <p>СЯ, БХБЯ, Монгол банк</p> <p>БХБЯ</p>
15	<p>"40 000 орон сууц" хөтөлбөрийн мастер болон бизнес төлөвлөгөөг боловсруулж батлах</p>	<p>2005 он</p>	<p>СЯ, БХБЯ, Монгол банк</p>
16	<p>-Иргэдэд урт хугацааны эзэл олгох санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох ажлыг зохион байгуулах</p>	<p>2005-2010</p>	<p>Монгол банк</p>
17	<p>-Орон сууцны барилга болон орон сууцны дэд бүтэц барьж байгуулах байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдийг бүртгэж судалгаа хийх</p>	<p>2005 оноос</p>	<p>БХБЯ</p>

18	-40 000 орон сууц, хөтөлбөрт оролцогч аж ахуйн нэгж, компаниудыг сонгож гэрээ байгуулж тэдгээрт оролцогчийн батламж олгох	2005 оноос	БХБЯ
19	-Орон сууцны барилга болон орон сууцны дэд бүтэц барьж байгуулах гадаадын байгууллага, аж ахуйн нэгжүүдийг бүртгэж сонгон газар олгож шаардлагатай бол тогтвортой байдлын гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах	2005 оны IV улиралд	БХБЯ,СЯ, ХЗДХЯ
20	-Гадаадын хоронго оруулалтаар баригдсан орон сууц, түүний дэд бүтцийг худалдах, худалдан авах гэрээ байгуулах	2005 -2006	БХБЯ, СЯ
21	-Төрийн албан хаагч, нийгмийн эмзэг хэсгийн иргэд хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болох нөхцөлийг бий болгох зорилгоор орон сууцны дэд хөтөлбөрүүдийг тусгайлан боловсруулж хэрэгжүүлэх	2005 оноос жил бүр	
22	-Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдуулан олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй зарим төслүүдийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор гэрээнд нь холбогдох өөрчлөлт оруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх		
23	-Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс шаардагдах хөрөнгийн хэмжээг жил бүр тогтоон УИХ-аар батлуулах ажлыг зохион байгуулах		
Г. Шинээр барих буюу нөхцөл сайжруулах чиглэлээр хүн амын худалдан авах чадварт нийцсэн 40 000 орон сууц барих чиглэлээр			
а/ Нийтийн зориулалттай 10 000 орон сууц барина			
24	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах		
25	Ерөнхий төлөвлөгөөний дагуу олгогдсон газарт нийтийн зориулалттай орон сууцны барилга барих байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулах	2005-2010	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
26	Хотын доторхи ашиглагдаагүй байгаа газарт одоо байгаа дэд бүтцийг ашиглах замаар шинээр орон сууц барих		
27	Оршин суугчдын саначилгын үндсэн дээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучин барилгуудыг буулгаж дахин барилгажуулах		
28	Техникийн шаардлага хангасан барилгад технологийн дагуу монсардан давхар нэмэх		
29	Шугам сүлжээнд бүрэн холбогдоогүй орон сууцныг шугам сүлжээнд холбож нөхцөлийг нь сайжруулах		
30	Орон сууцны баригдаж дуусаагүй барилгыг гүйцээх, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг орон сууцны зориулалттай болгон өөрчлөх боломжид судалгаа хийж, хэрэгжүүлэх	2005-2007	БХБЯ, ТӨХ, УМХГ Нийслэл, аймгийн ЗДТГ

Б/ Амины 15 000 орон сууц барина

31	Хотын захын ашиглалтгүй талбайд шинээр барих орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах.	2005-2010	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
32	Шинээр орон сууцны хотхон, хороолол барих газрыг байгууллага, аж ахуйн нэгжид (төсөл сонгон шалгаруулах болон дуудлага худалдаа) эзэмшүүлэх.		
В/Гэр хорооллыг орон сууцны анхан шатны дэд бүтэцтэй холбож 15 000 айлын орон сууцны нөхцөлийг сайжруулах замаар эдгээр гэр хорооллыг амины орон сууцны хотхон болгон хөгжүүлэх			
33	Гэр хорооллын дахин төлөвлөлтгүй олон нийтийн оролцоотой хийж эдлэн газартай орон сууцны хороолол болгон хөгжүүлэх /Дарь-Эх, Дамбадаржаа, Гандан, Яармаг, Нисэхийн гэр хорооллыг загвар болгон энхий ээлжинд хамруулах/	2005-2010	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
34	Орон сууцны анхан шатны дэд бүтцийг барьж байгуулах		
35	Орон сууцны анхан шатны дэд бүтэцэд гэр хорооллын аялж холбох ажлыг зохион байгуулах		
Д. Барилгын салбарт шинэ техник, технологи нэвтрүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар шинээр ажлын байр бий болгох чиглэлээр			
36	Канад болон бусад улсад мөрдөж буй хот байгуулалт, барилга, байгууламжийн норм ба дүрмийг судлан өөрийн орны норм, дүрэм, стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх.		
37	Шинээр мөрдөгдөх хот байгуулалт, барилга байгууламжийн норм, дүрмийг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлын талаар сургалт явуулах	2005 оноос	БХБЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ, УСГ
38	Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулах		
39	Орон сууцны барилгыг бүртгэлжүүлж мэдээллийн нэгдсэн системийг бий болгох		
40	Барилгын салбарт шинэ техник, технологи нэвтрүүлж, машин механизм, тоног төхөөрөмжийн гялзныг, турээсийн үйлчилгээ бий болгох		
41	Гадаад, дотоодын санхүүжилтийн эх үүсвэрээр барилгын салбарт нэвтрэх буй шинжлэх ухаан, шинэ техник, технологийн талаар сургалт явуулж өндөр мэргэжлийн ажилчдыг бэлтгэх	2005-2008	БХБЯ, БСШУЯ, НХХЯ, УХЯ, Нийслэл, аймгийн ЗДТГ
42	Барилгын төсвийн томогосон үнэлгээг бий болгох		
43	Барилгын эрдэм шинжилгээ, зураг төсөл, материаллын жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх		

Товчлолын тайлбар:

1. БХБЯ- Барилга, хот байгуулалтын яам
2. СЯ - Сангийн яам
3. БСШУЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
4. НХХЧ- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
5. УХЯ- Үйлдвэр, худалдааны яам
6. ЗДТГ- Засаг даргын Тамгын газар
7. УСГ -Үндэсний статистикийн газар
8. ТӨХ- Төрийн өмчийн хороо
9. УМХГ- Улсын мэргэжлийн хяналтын газар
10. МБ- Монгол банк
11. ХЗДХЯ- Хууль зүй, дотоод хэргийн яам



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ардын хувьсгалын 84 жилийн ойг тохиолдуулан дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай:

1. Лувсандандарын Хангай -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;

2. Нанцагийн Батсуурь -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

3. Чимэдийн Сайханбилэг - Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга;

4. Намжилын Чинбат - Оюуны өмчийн газрын дарга;

5. Аюушийн Намхай - Байгаль орчны яамны тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга;

6. Рэнцэндоогийн Жигжид - Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны Элчин зөвлөх;

7. Сэнгээгийн Цогтбаатар -Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга;

8. Сосорын Цэнд-Аюуш - Сангийн яамны салбарын бодлого, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн;

9. Лутын Сандаг - Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны төрийн захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн;

10. Түндэвийн Доржбал -Үйлдвэр, худалдааны сайдын зөвлөх;

11. Халтарын Пүрэвсүрэн-Багануур дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга;

12. Чүлтэмийн Жамбалсүрэн-Диспетчерийн үндэсний төв" ХХК-ийн дэд захирал;

13. Сангаажавын Мягмар-Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч;

14. Сүрэнхорын Махбариад -Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын хүн эмнэлгийн их эмч;

15. Дамбын Доржготов -Батлан хамгаалахын их сургуулийн тэнхмийн эрхлэгч;

16. Сүрэнжавын Пүрэв -Барилга-угсралтын "Тангар инвест" ХХК-ийн ерөнхий захирал;

17. Магилжавын Болд-Дуурь бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Жагсаалтад нэмэлт оруулах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйл, Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоолоор баталсан "Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалт"-ын Хоёрдугаар хэсэгт "4. "Алтанбулаг" худалдааны

чөлөөт бүс" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД

С. БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

үйлчилгээний газрын даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

Даваагийн Баярсайханыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөлмөр, халамжийн

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Ерөнхий байцаагчийн эрх олгох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

1. Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Баасанд Мэргэжлийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай"

**МОНГОЛ УЛСЫН
САЙД** **Д.ДОРЛИГЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Холбогдох байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

5. Архангай аймгийн Хангай сумын 8 жилийн дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш Ядамсүрэнгийн Шагдарсүрэнгийн.

1. Төв аймгийн Сэргэлэн сумын 8 жилийн дунд сургуулийг төр, нийгмийн зүтгэлтэн Догсомын Бодоогийн.

6. Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрыг төр, нийгмийн зүтгэлтэн Сономын Лувсанвандангийн.

2. Увс аймгийн Тэс сумын Хар-Үзүүрийн бага сургуулийг Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Мөнхийн Чулууны.

7. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 10 жилийн дунд сургуулийг Монгол Улсын төрийн шагналт зохиолч Бямбын Ренчингийн нэрэмжит тус тус болгосугай.

3. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 10 жилийн дунд сургуулийг Монгол Улсын төрийн шагналт зохиолч Сормуунришийн Дашдооровын.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **Ц.ЭЛБЭГДОРЖ**

4. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 жилийн нэгдүгээр дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш Базарын Гомбын.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД** **П.ЦАГААН**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2005 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан "Олон хүүхэдтэйн тэтгэмж олгох журам"-д дараахь агуулгатай хэсэг нэмсүгэй:

1.1. "2.4. Энэ журмын 2.3-т заасан аргачлалаар "ядуу", "нэн ядуу" гэсэн ангилалд багтах ерх, иргэн хамрагдана."

1.2. "8.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийн олголт болон энэ талаархи үйл ажиллагааны тайлан, мэдээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт улирал тутам хүргүүлж байна."

2. Журмын гарчгийг "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам" гэж, 2.1-ийн "...0-18 хүртэл насны гурав ба түүнээс дээш хүүхэдтэй..." гэснийг "...1-18 хүртэл насны хүүхэдтэй..." гэж тус тус өөрчилсүгэй.

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

3. Журмын "3.2, 3.3-ын "...3.2-т..." гэснийг тус тус хассугай.

4. Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохтой холбогдон маягт, дэвтэр хэвлэх, тээвэрлэх зардалд шаардагдах 73.5 /далан гурван сая таван зуун мянган/ сая төгрөгийг 2005 оны төсвийн багцаасаа гаргахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайханд зөвшөөрсүгэй.

5. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "48."Улсын мэргэжлийн хяналтын тэргүүний ажилтан" тэмдэг-Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд" гэж нэмсүгэй.

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

2. "Улсын хяналтын тэргүүний ажилтан" тэмдгийг олгох журмыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын сайд Д.Дорлигжавт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
САЙД

Д.ДОРЛИГЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан 1 дүгээр хавсралтад

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

"48.Мэргэжлийн хяналтын ажилтны өдөр-6 дугаар сарын хоёр дахь Ням гараг" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
САЙД

Д.ДОРЛИГЖАВ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах улсын албад байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

албадын дарга нарт, улсын албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүхэд үүрэг болгосугай.

1. Гамшгаас хамгаалах улсын албад, тэдгээрийн дарга нарыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

2. Улсын албадын бүрэлдэхүүнийг томилж, тэдний гүйцэтгэх үүргийг тогтоож өгөхийг улсын

МОНГОЛ УЛСЫН
САЙД

У.ХҮРЭЛСҮХ

Засгийн газрын 2005 оны 158 дугаар тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАД

№	Улсын албадын нэр	Түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага	Улсын албаны дарга
1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба	Байгаль орчны яам	Байгаль орчны сайд
2	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн сайд
3	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуйн яам	Хүнс, хөдөө аж ахуйн сайд
4	Түлш, эрчим хүчний алба	Түлш, эрчим хүчний яам	Түлш, эрчим хүчний сайд
5	Цацрагийн аюулаас хамгаалах алба	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
6	Зам, тээврийн алба	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам	Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд
7	Барилга, хот байгуулалтын алба	Барилга, хот байгуулалтын яам	Барилга, хот байгуулалтын сайд
8	Мэргэжлийн хяналтын алба	Улсын мэргэжлийн хяналтын газар	Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд
9	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга
10	Хэв журам сахиулах алба	Цагдаагийн ерөнхий газар	Засгийн газрын тохируулагч агентлаг-Цагдаагийн ерөнхий газрын дарга
11	Сурталчилгааны алба		Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албаны дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Комиссын ажиллах журам, бүрэлдэхүүн багтах тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 34 дүгээр тогтоолыг хүчингүй болгонд тооцсугай.

1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах үүрэг бүхий Гамшигтай тэмцэх комиссын ажиллах журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
САЙД

У.ХҮРЭЛСҮХ

Засгийн газрын 2005 оны 159 дүгээр
тогтоолын хаесралт

ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гамшигтай тэмцэх комисс /цаашид "комисс" гэх/-оос хэрэгжүүлж байгаа гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Комисс нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

3. Комиссын үйл ажиллагаа нь онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын шийдвэрээр эхэлж гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулан, шуурхай зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт танилцуулснаар дуусгавар болно.

4. Комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд даргална.

5. Комисс нь гамшигийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэж, олонхийн санал дээр үндэслэн шийдвэр гаргана.

Хоёр. Комиссын бүрэн эрх

6. Комисс дараахь эрхтэй байна:

6.1. Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, иргэдийг хууль тогтоомжийн дагуу татан оролцуулах;

6.2. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах;

6.3. Гамшигийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах, илэрсний зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авах.

7. Комисс дараахь үүрэгтэй байна:

7.1. Гамшигийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

7.2. Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаатай холбоотой нэмэлт зардал, бараа материал, ажиллах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гаргах асуудлаар санал боловсруулж Засгийн газарт оруулах;

7.3. Гамшигийн цагийн байдлын талаар төр, засгийн удирдлагад шуурхай мэдээлэх, тэдний өгсөн үүрэг даалгаврын дагуу ажиллах.

Гурав. Комиссын чиг үүрэг

8. Комисс нь гамшигийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах үйл ажиллагааг явуулахдаа дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1. Гамшигийн цагийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

8.2. Хорио цээрийн дэглэм сахиулах, харуул, хамгаалалтын ажил зохион байгуулах;

8.3. Гамшигийн голомтод ажиллах бүрэлдэхүүнийг тогтоож, дэд бүтцийн асуудлыг зохих байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэх, зохицуулах;

8.4. Гамшигийн голомт, түүний орчинд гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

8.5. Нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

8.6. Гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах ажлыг зохион байгуулах, байршуулах;

8.7. Шаардлагатай гэж үзвэл гамшигийн голомттой харилцах дундын цэгийг байгуулах, гамшигийн голомт болон түүний орчны бүсэд ажиллаж байгаа хүн, машин техникийн хангалт үйлчилгээний асуудлыг шийдвэрлэж зохион байгуулах, уялдуулан зохицуулах.

Дөрөв. Санхүүжилт

9. Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг Онцгой байдлын ерөнхий газраас гаргасан тооцоог үндэслэн Засгийн газрын шийдвэрээр санхүүжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах талаар хийгдэж байгаа судалгаа, төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах зорилгоор Сэргээгдэх эрчим хүчний /СТҮБ/ корпораци, "Нарны гэр" төслийн нэгж, Засгийн газрын тохируулагч агентлаг- Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын харьяа "Нарны зайн үйлдвэр"-ийг нэгтгэн Түлш, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийг байгуулсугай.

2. Сэргээгдэх эрчим хүчний /СТҮБ/ корпораци, "Нарны гэр" төслийн нэгж, "Нарны зайн үйлдвэр"-ийн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг балансаас балансад орон тоо, төсвийн хамт Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвд шилжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаан, Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүү, Төрийн өмчийн хороо /З.ЭНХБОЛД/, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэгт тус тус даалгасугай.

3. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталж мөрдүүлэхийг Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүүд даалгасугай.

4. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн төсвийг баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Н.Алтанхуягт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шинжлэх ухааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 31 дүгээр тогтоолын хавсралтын "Төрийн өмчид түшиглэсэн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн /СТҮБ/ корпорациуд" гэсэн "Б" хэсгийн 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ
САЙД

Т.ОЧИРХҮҮ

Залруулга

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны 27 дугаарт нийтлэгдсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "тамхи импортлох" гэсэн 15.10.13 дахь заалтын дугаарыг "15.10.14" гэж, 2 дугаар зүйлийн "15.10.13," гэснийг "15.10.14," гэж тус тус залруулна уу.

УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТЭС

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12,
Төрийн ордон
☎ 265958 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэлтэст хэвлэв.
☎ 267497
Хэвлэлийн хуудас 2.5